

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	2
ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар	АУДИТ ХИЙГДСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	5
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор:	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	5
	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	6
	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	7
Ц.Наранчимэг	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	7
Аудитын менежер:	Товчилсон үгийн жагсаалт	9
Г.Гүнжидмаа	Аудитын талаарх үндсэн мэдээлэл	10
Я.Самбууням	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ	10
Ахлах аудитор:	Санхүүгийн дотоод хяналт	13
	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	13
Ш.Ичинхорлоо	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН	15
Ц.Хосжаргал	Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15
Г.Жавхлан	1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	15
	1.1.1 Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө	15
	1.1.2 Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	16
	1.1.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө	17
Л.Хонгорзул	1.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	18
Аудитор:	Хоёр. Богино хугацаат хөрөнгө оруулалт	18
П.Чанцалдулам	2.1 Нийгмийн даатгалын сангийн богино хугацаат хөрөнгө оруулалт	18
	Гурав. Авлага, урьдчилгаа	19
Б.Сэржмядаг	3.1. Авлага	19
	3.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын авлага	19
	3.1.2 Төв төрийн сангийн авлага	19
Р.Цолмон	3.1.3 Нийгмийн даатгалын сангийн авлага	20
	3.1.4 Төрийн өмчит хуулийн этгээдийн авлага	21
Ж.Болормаа	3.1.5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлага	21
	3.2 Урьдчилгаа	22
Ц.Цэрэнхүү	Дөрөв. Урт хугацаат хөрөнгө оруулалт	22
	Тав. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө	23
Б.Долгоржав	5.1 Бараа материал	23
	5.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал	23
	5.1.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн бараа материал	23
Н.Золзаяа	5.1.3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал	23
	5.2 Бусад эргэлтийн хөрөнгө	24
Н.Нямдаваа	Зургаа. Үндсэн хөрөнгө	24
	6.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө	24
	6.2 Нийгмийн даатгалын сангийн үндсэн хөрөнгө	24
Б.Баярмаа	6.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө	25
	6.4 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө	25
2017 оны 6 дугаар сар	Долоо. Өр төлбөр	26
Уг тайланг ҮАГ-ын	7.1 Богино хугацаат зээлийн өглөг	28
Цахим хуудаснаас үзнэ үү:	7.2 Дансны өглөг	28
www.audit.mn	7.3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр	29
	Найм. Засгийн газрын хувь оролцоо	29
	8.1 Төрийн өмчийн хувь оролцоо	30
	8.2 Орон нутгийн өмчийн хувь оролцоо	31
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаарын утсаар харилцана уу.	Ес. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн	31
	9.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	31
	9.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	31
ХАЯГ:	9.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	32
Үндэсний аудитын газар	9.4 Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	32
Засгийн газрын IV байр,	9.5 Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудит	33
Бага тойруу-6, Улаанбаатар-46	Арав. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга	33
Монгол Улс	Арван нэг. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, албан шаардлагын биелэлт	33
	АУДИТЫН ДҮГНЭЛТ	34
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	35
	АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	37

1. Засгийн газрын 2016 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Барилга, хот байгуулалтын сайд, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд тус тус "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн;
2. "Эрдэнэс Таван толгой" ТӨХК-ийн санхүүгийн тайланд Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу төр, иргэн, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэхтэй холбоотой хувьцааг бүртгээгүй, хувь нийлүүлсэн хөрөнгийг тайланд тусгаагүй;
3. Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн 419.9 тэрбум, Төсвийн ерөнхийлөн захирагчдын 377.6 тэрбум, орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын 21.7 тэрбум, төрийн өмчт хуулийн этгээдийн 22.5 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
4. Гадаад зээлийн хөрөнгөөс орон нутагт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 71.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн 75.7 тэрбум төгрөгийн үндсэн болон хуулийн төлбөрийг төлүүлэх талаар арга хэмжээ авч агаагүй;
5. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Банк, хадгаламж зээлийн хоршоосдын төлбөр барагдуулах ажлын албаны авлага, ар төлбөрийн үлдэгдэл нийт 2.7 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан;
6. Монгол Улсын Хөгжлийн банкнаас улсын төсвөөс эрсэн төлөгдөх нөхцөлтэй авсан зээлээр санхүүжүүлсэн 176 төсөл арга хэмжээний 594.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд бүрэн тайлагнаагүй;
7. Эрчим хүчний яам нь 217.7 тэрбум төгрөгийн өртөгтэй Мандатговь-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн Цахилгаан дамжуулах дэд станцыг 118.2 тэрбум төгрөгөөр буюу 99.5 тэрбум төгрөгийн зөрүүтэй данс бүртгэлд тайлагнасан;
8. Гадаад харилцааны яам "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зоржулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн хөрөнгөөс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэртэй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагуудад 1.2 тэрбум төгрөгөөр худалдсан, 1.9 тэрбум төгрөгийн /тавлийн үнэлгээгээр/ орчуулгын тоног төхөөрөмжийг түрээслүүлсэн, 12.4 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын журмыг зөрчиж шууд худалдан авалт хийсэн;
9. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна" гэж заасны дагуу зарим төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгүй;

2016.12.15.20160409_Аудитын тайлан_Бүтэц/20170808/3/Салбар/Салбар

10. Төрийн өмчт 60 хуулийн этгээд 2016 оны дашууран зоригтат туццна биецүүтээгүй, санхүүгийн тайлчанаар тасан андгдзат нь 2015 оноос 354 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн
11. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй сум дундан нийгмийн даатгалын тасгуудын барилгын ажиллалтын зардлыг тооцоллоггүйгээр барьсан байна

Хизмәтләшкән сәһә дүгмәт:

Дээрх зарчлалтай асуудлуудын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлж болохгүй нөлөөллийг эс тооцвол, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусшар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөтөмчийн өөрчлөлт болон мянган гүйцэтгэлийг нэгтгэсэн тайланг УСНБЕОУС-д нийлүүлж Сангийн сайрын баталсан бодлого, эргэлцэл, журмын дагуу материаллаг гүйцлийн хувьд үнэн, зөв илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

ДХҮРЭЛБААТАР

АУДИТ ХИЙГДСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		11,578,851,089.8	12,334,368,711.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	3,242,461,163.4	2,925,451,980.7
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	124,717,117.2
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	6,203,652,680.1	4,627,216,596.3
УРЬДЧИЛГАА	7а, 7б	715,442,195.5	849,297,462.0
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,305,706,324.5	1,055,566,620.8
НӨӨЦИЙН БАРАА	9а	100,124,830.9	147,050,062.3
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		11,463,895.7	2,605,068,871.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		18,260,993,884.7	18,825,596,126.2
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	6,034,510,526.7	5,565,885,731.8
Урт хугацаат хадгаламж		63,100,000.0	1,170,781,806.5
Үнэт цаас		209,768.4	240,637,257.3
Урт хугацаат зээл		5,971,200,758.3	4,154,466,668.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	12,226,483,357.9	13,259,710,394.3
Газар		606,490.3	606,490.3
Биет хөрөнгө		11,942,516,267.5	12,397,940,470.6
Биет бус хөрөнгө	13	274,536,406.3	377,959,829.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/		8,824,193.8	483,203,604.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		29,839,844,974.5	31,159,964,837.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР		19,685,123,763.4	24,843,660,939.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,794,299,018.2	3,854,807,852.1
Богино хугацаат үнэт цаас		1,113,174,089.8	1,825,741,379.6
Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	1,103,479,619.9	548,711,482.7
Өглөг	17а, 17б	3,254,631,897.5	1,133,436,776.9
Урьдчилж орсон орлого	18а, 18б	323,013,411.0	346,918,212.9
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19	13,890,824,745.1	20,988,853,087.6
Урт хугацаат үнэт цаас		5,479,175,483.4	7,932,106,664.3
Урт хугацаат зээл	20а, 20б	8,411,649,261.7	13,056,746,423.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		10,154,721,211.2	6,316,303,897.5
Засгийн газрын хувь оролцоо		10,154,721,211.2	6,316,303,897.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		6,697,680,855.6	4,155,062,099.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		980,903,128.7	2,860,724,535.4
Өмч /хувийн/ /ТӨҮГ/		40,920.7	175,110.7
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		264,158.4	38,355,868.4
Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		19,108,475.4	33,784,215.5
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		681,569,435.8	2,352,268,265.7
Хуримтлагдсан үр дүн		-190,021,906.3	-5,032,738,590.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,954,324,277.2	1,892,819,280.2
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		10,873,204.0	15,853,112.3
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		-21,338.3	0.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		29,839,844,974.5	31,159,964,837.2

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тод- руулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		9,825,070,401.4	10,103,227,047.9
ТАТВАРЫН ОРЛОГО		5,321,177,592.4	5,039,314,534.3
Орлогын албан татвар		1,226,693,285.6	1,044,091,549.0
Хувь хүний орлогын албан татвар		574,867,557.7	568,272,475.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-42,137,854.8	-44,821,546.9
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		5,466,790.9	681,916.2
ААН-ын орлогын албан татвар		688,496,791.8	519,958,703.8
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		1,151,332,284.7	1,261,837,671.8
Хөрөнгийн албан татвар		86,613,260.8	104,662,923.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар		1,049,588,711.4	1,140,721,391.9
Онцгой албан татвар		592,323,616.5	630,124,810.0
Тусгай зориулалтын орлого		11,791,799.0	10,767,441.6
Гадаад үйл ажиллагааны орлого		320,594,850.8	328,490,630.4
Бусад татвар, төлбөр, хураамж		882,239,783.6	518,618,115.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,789,563,624.3	4,669,318,700.1
Нийтлэг татварын бус орлого		3,563,317,695.6	4,447,058,099.5
Хөрөнгийн орлого		75,906,148.0	16,237,524.2
Тусламжийн орлого		137,191,173.6	204,598,584.9
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		6,631,100.3	1,424,491.5
Зээлийн орлого		6,517,506.9	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		714,329,184.7	394,593,813.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	8,866,364,055.4	10,598,820,694.5
УРСГАЛ ЗАРДАЛ		8,099,407,160.7	10,029,513,180.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,661,952,812.0	5,658,579,494.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,957,420,693.0	1,978,991,327.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		174,429,046.1	186,226,818.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		210,037,663.0	240,710,454.6
Хангамж, бараа материалын зардал		336,032,128.5	523,531,329.0
Нормативт зардал		237,208,376.4	267,746,365.2
Эд хогшил, урсгал засварын зардал		60,066,671.2	73,982,824.2
Томилолт, зочны зардал		67,474,586.2	64,032,637.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		832,902,056.5	1,108,360,418.3
Бараа үйлчилгээний бусад зардал		786,381,591.2	1,214,997,320.0
ХҮҮ		776,079,382.8	1,592,529,267.1
ТАТААС		218,379,020.7	301,990,417.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,442,995,945.2	2,476,414,001.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		766,956,894.7	569,307,514.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		958,706,345.9	-495,593,646.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		145,735,908.6	632,214,343.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		653,266,017.7	3,631,316,847.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		451,176,236.7	-3,494,696,150.2

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,219,139,601.5	0.0	9,219,139,601.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,374,881,467.8	0.0	1,374,881,467.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,594,021,069.3	0.0	10,594,021,069.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	583,541,670.8	0.0	583,541,670.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-1,481,178,292.1	0.0	-1,481,178,292.1
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	7,160,526.3	0.0	7,160,526.3
Тайлант үеийн үр дүн	451,176,236.9	0.0	451,176,236.9
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,154,721,211.2	0.0	10,154,721,211.2
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,154,721,211.2	0.0	10,154,721,211.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,355,700,985.0	0.0	-1,355,700,985.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,799,020,226.2	0.0	8,799,020,226.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-80,758,341.7	0.0	-80,758,341.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,088,142,026.1	0.0	1,088,142,026.1
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	4,596,137.2	0.0	4,596,137.2
Тайлант үеийн үр дүн	-3,494,696,150.2	0.0	-3,494,696,150.2
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,316,303,897.5	0.0	6,316,303,897.5

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		15,010,714,861.0	12,952,213,141.8
ТАТВАРЫН ОРЛОГО		4,942,028,602.1	5,653,252,571.4
Орлогын албан татвар		1,054,543,060.5	1,670,461,373.5
Хувь хүний орлогын албан татвар		527,359,251.6	1,194,915,661.3
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-43,114,708.6	-44,821,546.9
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчийн орлогын албан татвар		5,469,404.2	681,916.2
ААН-ын орлогын албан татвар		564,829,113.3	519,685,342.9
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		1,111,605,165.3	1,240,678,858.1
Хөрөнгийн албан татвар		86,613,260.8	104,660,748.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар		1,005,203,868.6	1,124,291,253.2
Онцгой албан татвар		592,323,616.5	630,124,810.0
Тусгай зориулалтын орлого		11,791,799.0	10,767,441.6
Гадаад үйл ажиллагааны орлого		272,638,176.1	328,490,630.4
Бусад татвар, төлбөр, хураамж		807,309,655.3	543,777,456.8

Бусад нийтлэг төлбөр, хураамж		666,228,670.8	382,369,943.9
Газрын төлбөр		59,630,564.2	53,591,386.5
Байгалийн нөөц ашигласны төлбөр		44,503,430.4	53,189,623.2
Бусад татвар		36,946,990.0	54,626,503.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		9,295,055,200.5	6,223,667,706.0
Нийтлэг татварын бус орлого		9,153,948,035.4	6,129,645,496.3
Хөрөнгийн орлого		57,127,371.5	1,193,612.7
Тусламжийн орлого		82,185,900.5	91,404,105.5
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		1,793,893.1	1,424,491.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		773,631,058.4	1,075,292,864.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		15,074,411,246.5	13,548,036,264.5
УРСГАЛ ЗАРДАЛ		15,074,411,246.5	13,548,036,264.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,714,187,689.8	9,670,313,987.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,231,437,010.5	2,295,089,090.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		257,113,048.6	268,171,997.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		280,651,843.7	342,247,310.9
Хангамж, бараа материалын зардал		789,875,565.5	1,189,333,545.1
Нормативт зардал		214,407,791.5	266,181,539.3
Эд хогшил, урсгал засварын зардал		55,607,730.0	61,414,902.8
Томилолт, зочны зардал		66,975,562.0	64,403,385.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,378,344,433.6	3,443,913,764.0
Бараа үйлчилгээний бусад зардал		439,774,704.4	1,739,558,452.5
ХҮҮ		1,172,841,977.3	972,418,471.3
ТАТААС		221,553,588.7	224,801,413.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,965,827,990.8	2,680,502,391.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		-63,696,385.5	-595,823,122.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		128,219,132.2	485,812,365.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		1,572,376,600.0	2,165,695,899.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,572,376,600.0	2,165,695,899.8
Дотоод эх үүсвэрээр		1,572,376,600.0	2,165,695,899.8
Гадаад эх үүсвэрээр		0.0	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-1,444,157,467.8	-1,679,883,534.2
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		1,269,170,852.6	1,958,697,474.2
Бусад эх үүсвэр		2,361,322,209.8	5,092,928,989.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		245,080,752.5	786,060,768.9
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР		579,302,156.7	2,039,776,348.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		267,768,448.0	308,394,397.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-238,683,000.7	-317,009,182.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,481,144,164.1	3,242,461,163.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,242,461,163.4	2,925,451,980.7

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АОУС	Аудитын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АСЕМ	Ази, Европын дээд түвшний уулзалт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУВС	Олон улсын валютын сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТС	Төв төрийн сан
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим бөгөөд хамарсан асуудлууд болно.

Төрийн аудитын байгууллага Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, зарим төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг Засгийн газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнгээс 2.0 хувь буюу 284.6 тэрбум төгрөгөөр тогтоосон болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 дахь заалтын дагуу Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргаж, хуульд заасан хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д заасны дагуу дараах байдлаар бэлтгэсэн:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллага хооронд үүссэн 29,028.6 тэрбум төгрөгийн давхардсан ажил гүйлгээ, орлого болон зардлыг цэвэрлэж тайлагнасан;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллага, төсөл, хөтөлбөр, сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 53 ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлан, 23 ТТЗ, 4952 төсвийн байгууллага, төрийн сан, 18 Засгийн газрын тусгай сан, 375 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 1100 төсөл, хөтөлбөр, 52 хөрөнгө оруулалтын болон бусад зардал, нийт 6573 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 –т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.” гэж заасны дагуу 100 хувийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хамруулсан байна.

Сангийн яам төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК, “Багануур” ХК зэрэг хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд үе шаттай хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах зорилтын хүрээнд үе шаттай ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Мөн Сангийн яамнаас “Э-тайлан” програм системийг хөгжүүлж, тус програмаар Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайланг нэгтгэснээр цэвэрлэх бичилтийн хамрах хүрээг нэмэгдүүлж чадсан, бүх шатны төсвийн байгууллагуудын тайланг хамруулсан өгөгдлийн нэг баазтай болсон, интернетийн орчинд ажилладаг, хяналт, аудит хийх нөхцөлийг нэмэгдүүлж өгсөн давуу талтай байна.

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
Засгийн газрын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	

Нягтлан бодох бүртгэлийн зарчим

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдсэн байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансны Монголбанк дахь үлдэгдэл;
- Төсөвт байгууллага, төсөл, хөтөлбөрийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Банкны харилцахын гадаад валютаарх үлдэгдэл;
- Кассанд байгаа бэлэн мөнгө;
- Замд яваа мөнгөн хөрөнгө;
- Хадгаламж;
- 3 сар хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалт.

Мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө нь богино хугацаатай, өндөр хөрвөх чадвартай хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хөрөнгө байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалтад Засгийн газраас гаргасан богино хугацаат үнэт цаас, бонд хамаарна.

Авлага

Авлага нь богино хугацаат дансны авлага, зээлийн авлага болон урьдчилгаанаас бүрдэнэ.

Урт хугацаат зээлийн авлага

Урт хугацаат зээлийн авлага нь Засгийн газрын байгууллагуудын бусдад нэг жилээс дээш хугацаанд зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийн жилийн эцэст төлөгдөөгүй байгаа үлдэгдэл дүнг илэрхийлнэ. Зээлийн авлагыг төлөгдөх дүнгээр нь хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материал

Бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар тодорхойлжээ.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь болон Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төсөвт байгууллагын үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр хүлээн зөвшөөрсөн.

Төсвийн захирагчид 2016 онд үндсэн хөрөнгөд УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө” стандартын дагуу элэгдэл байгуулжээ.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй боловч ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага юм.

Богино хугацаат өр

Богино хугацаат өр төлбөр нь нэг жилийн дотор барагдуулах ёстой өр төлбөрийг илэрхийлнэ.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд барагдуулах үүрэг хариуцлага юм.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Арилжааны бус орлого болох татвар, хураамж, торгууль, шимтгэлийг цуглуулсан үед нь, харин бараа, үйлчилгээг төлбөртэйгөөр хүргэсэн үед арилжааны (хэрэгжсэн) орлогыг тохируулсан аккрузл сууриар хүлээн зөвшөөрсөн байна.

Зардал

Нягтлан бодох бүртгэлийн аккрузл зарчмын дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрсөн байна.

Дотоод аудит

Төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*”, 69.2-т “*Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана.*” гэж заасны дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь дотоод аудитын албадыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангадаг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй байгаа нь дотоод аудитын албад харьяа байгууллагуудынхаа санхүүгийн үйл ажиллагааг шалгах, зөрчлийг илрүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах зэрэг үйл ажиллагаа хангалтгүй хийж байгаатай холбоотой байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь мөнгөн хөрөнгө 2,925.5 тэрбум, богино хугацаат хөрөнгө оруулалт 124.7 тэрбум, авлага болон урьдчилгаа 5,476.5 тэрбум, бараа материал, нөөц, бусад эргэлтийн хөрөнгө 3,807.7 тэрбум, урт хугацаат хөрөнгө оруулалт 5,565.9 тэрбум, үндсэн хөрөнгө 13,259.7 тэрбум, нийт 31,160.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 1,320.1 тэрбум буюу 4.4 хувиар нэмэгдсэн байна.

Эргэлтийн хөрөнгө өмнөх оноос 0.8 пунктээр өссөн нь бусад эргэлтийн хөрөнгө 2,593.6 тэрбум төгрөгөөр, нийт өр төлбөр 13.7 пунктээр өссөн нь урт хугацаат өр төлбөр 7,098.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн сүүлийн 3 жилийн үзүүлэлтэд хийсэн санхүүгийн тайлангийн шинжилгээгээр тайлант онд нийт хөрөнгийн 39.6 хувийг эргэлтийн хөрөнгө, 60.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Харин цэвэр хөрөнгийн эзлэх хувь 20.3 болж, нийт өр төлбөр 79.7 хувьд хүрч өмнөх оноос 13.7 пунктээр өссөн байна.

Мөнгөн хөрөнгө сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байгаа ба өмнөх оноос 317.0 тэрбум төгрөгөөр буюу 1.5 пунктээр, авлага 1,576.5 тэрбум төгрөгөөр буюу 5.9 пунктээр тус тус буурсан нь хөрөнгийн түргэн хөрвөх чадварыг бууруулж байна.

Урт хугацаат өр төлбөр өмнөх оноос 7,098.1 тэрбум төгрөг буюу 51.1 хувиар өссөн харин богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1,939.5 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар буурч нийт өр төлбөр 5,158.6 тэрбум төгрөгөөр буюу 26.2 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар нийт зардал нь нийт орлогоосоо 3,494.7 тэрбум төгрөгөөр илүү байгаа нь гадаад валютын ханшийн зөрүүний гарз 2,984.4 тэрбум, эргэж төлөгдөх зээлд 431.4 тэрбум төгрөг төлсөн зэрэг бусад зардлаас шалтгаалжээ.

Тайлант онд урсгал зардал өмнөх оноос 1,930.1 тэрбум төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний зардал 996.7 тэрбум, хүүгийн зардал 816.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн зэрэг бусад зардалтай холбоотой байна.

Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 396.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан, төрийн сангийн нийт зардал нь орлогоосоо 4,949.9 тэрбум төгрөгөөр илүү байна.

Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2016 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланд засгийн газрын хувь оролцоо 3,838.4 тэрбум төгрөгөөр буурсан нь Засгийн газрын оруулсан капитал, хуримтлагдсан үр дүнг хорогдуулсантай холбоотой байна.

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2016 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 317.0 тэрбум төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-д заасны дагуу тодруулга бүрд тайлбар, тэмдэглэлийг бүрэн хийгээгүй байна.
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлийн үед өглөг, авлагын цэвэрлэх бичилтийн хамрах хүрээ нэмэгдэж байгаа хэдий ч, Төв төрийн сан, ТЕЗ-дын харьяа байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өр, авлагын тооцоог бүрэн хийж баталгаажуулдаггүйгээс 821.3 тэрбум төгрөгийн авлага /дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага/, 201.3 тэрбум төгрөгийн байгууллагад өгөх өр, төлбөрийн давхардсан гүйлгээний цэвэрлэх бичилтийг хийгээгүй байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,925.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 317.0 тэрбум төгрөг буюу 9.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая.төг/ Дүнд эзлэх хувь
Кассанд байгаа бэлэн мөнгө	55,349.0	71,380.5	16,031.5	2.4
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,517,689.1	2,042,784.3	-474,904.8	69.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	4,187.3	6,892.6	2,705.3	0.2
Хадгаламж	665,235.8	804,394.7	139,158.9	27.5
Нийт дүн	3,242,461.2	2,925,452.1	-317,009.1	100.0

Нийт мөнгөн хөрөнгийн 69.8 хувь нь Төрийн сан, Монголбанк, арилжааны банкуудад, 27.5 хувь нь хадгаламж хэлбэрээр, 2.4 хувь нь байгууллагуудын кассанд бэлнээр, 0.2 хувь нь замд яваа мөнгөн хөрөнгө байна.

Банкинд байршиж байгаа 2,042.8 тэрбум төгрөгийн 680.6 тэрбум төгрөг нь гадаад валютаар байна.

Нийт 804.4 тэрбум төгрөгийн хадгаламжаас 13.2 тэрбум төгрөг нь Төв төрийн сангийн, 17.5 тэрбум төгрөг нь БСШУСС-ын харьяа их дээд сургуулиудын, 190.7 тэрбум төгрөг нь Сангийн сайдын харьяа төрийн өмчит хуулийн этгээд болон Тогтворжуулалтын сангийн, 583.0 тэрбум төгрөг нь НДС-гийн мөнгөн хөрөнгө байна.

1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

ТЕЗ-дын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,632.7 тэрбум төгрөг нь нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 90.0 хувийг эзэлж байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэж заасан байна.

Төв төрийн сангаас гаргаж өгсөн мэдээллээс үзэхэд Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр төсвийн 1 байгууллага, 1 сан төрийн сангаас гадуур харилцах дансаар гүйлгээ хийж, эдгээр данс 0.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

1.1.1. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сан оны эхэнд 286.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 9.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 295.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 2. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төг/ Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	282,724.3	276,778.7	-5,945.6
Төгрөг	13,250.4	23,301.8	10,051.4
Монголбанк дахь харилцах	3,635.3	7,250.6	3,615.3
Арилжааны банк дахь харилцах	9,615.1	16,051.2	6,436.1
Гадаад валют	269,473.9	253,476.9	-15,997.0
Монголбанк дахь харилцах	261,003.1	253,476.9	-7,526.2
Бусад төсөл, нөөцийн харилцах	8,470.8		-8,470.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	3,675.5	5,754.4	2,078.9
Хадгаламж		13,200.0	13,200.0
Нийт дүн	286,399.8	295,733.1	9,333.3

Хүснэгт 3. Төв төрийн сангийн 2016 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Валютын төрөл	Валютын үлдэгдэл /сая. нэгж/	Монголбанкны 2016.12.30-ны хаалтын ханш	Эцсийн үлдэгдэл /сая.төг/
Монголбанк дахь харилцах /төгрөгөөр/				7,250.6
Монголбанк дахь харилцах /валютаар /:				253,476.9
Улсын төсвийн валютын харилцах /доллар/	USD	79.7	2,489.53	198,398.5
Дамжуулан зээлийн тусгай харилцах доллар	USD	4.3	2,489.53	10,655.1
Улсын төсвийн валютын харилцах евро	EUR	0.3	2,605.79	882.3
Улсын төсвийн валютын харилцах иен	JPY	145.8	21.19	3,088.4
Дамжуулан зээлийн тусгай харилцах доллар	USD	0.2	2,489.53	461.1
Хувийн хэвшлийг дэмжих 2 дахь төслийн эргэлтийн сан	USD	0.7	2,489.53	1,635.9
АНУ-ын нөхөн төлбөрийн данс	USD	-	2,489.53	-
Сангийн яам юань	CHY	37.6	357.96	13,460.3
Засгийн газрын өрийн батлан даалтын сан	USD	10.0	2,489.53	24,895.3
Арилжааны банк дахь харилцах /төгрөгөөр/				16,051.2
Замд яваа хөрөнгө				5,754.4
Хадгаламж /Хөгжлийн банк /				13,200.0
Нийт дүн				295,733.1

1.1.2 Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 873.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 172.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төг/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	0.5	1.0	0.5
Харилцах данс	234,274.7	290,164.8	55,890.1
Замд яваа мөнгө	-	119.6	119.6
Хадгаламж	467,000.0	583,000.0	116,000.0
ДҮН	701,275.2	873,285.4	172,010.2

Нийгмийн даатгалын сангуудын харилцах дансдын эцсийн үлдэгдэл өмнөх оноос 55.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 290.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 113.2 тэрбум

төгрөг төрийн сангийн харилцах дансад, 177.0 тэрбум төгрөг арилжааны банкуудын харилцах дансад тус тус байршиж байна.

Тайлант онд Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 116.0 тэрбум төгрөгийг хадгаламжийн дансад нэмж байршуулсан ба 2016 оны жилийн эцэст 583.0 тэрбум төгрөгийн хадгаламж арилжааны 9 банкинд байршиж байна. БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэд тус улсын арилжааны банкуудад 0.04 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого байршуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс 2014 онд 532.0 тэрбум, 2015 онд 467.0 тэрбум, 2016 онд 583.0 тэрбум төгрөгийг арилжааны 9 банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсан байна.

Хүснэгт 5. Банкнд байршуулсан хадгаламж

Банкны нэр	/сая.төг/			
	ҮОМШӨ-ний даатгалын сан	Эрүүл мэндийн даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	Нийт дүн
Улаанбаатар хотын банк	51,156.0	61,055.0	46,789.0	159,000.0
Голомт банк	17,350.0	32,650.0	-	50,000.0
Капитал банк	35,810.0	111,888.0	32,302.0	180,000.0
Капитрон банк	16,100.0	8,900.0	5,000.0	30,000.0
Төрийн банк	14,000.0	21,000.0	-	35,000.0
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	26,800.0	3,200.0	5,000.0	35,000.0
Хаан банк	6,000.0	-	-	6,000.0
ХХБ	40,000.0	-	-	40,000.0
Чингис хаан банк	40,620.0	6,410.0	970.0	48,000.0
Нийт дүн	247,836.0	245,103.0	90,061.0	583,000.0

2014 онд 44.4 тэрбум төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлого төвлөрүүлж байсан бол 2015 онд 56.0 тэрбум, 2016 онд 51.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оноос 4.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2016 онд хадгаламжид байрших мөнгөн хөрөнгийн хэмжээ өссөн боловч хүүгийн түвшин нь Монголбанкны бодлогын хүүтэй холбоотойгоор буурсан байна.

Хүснэгт 6. Хадгаламжийн хүүгийн өөрчлөлт

Хүүгийн хэмжээ			
Монголбанкны бодлогын хүү/Овернайт хадгаламжийн хүү		Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор	
Огноо	хүүгийн хэмжээ	Огноо/Тогтоолын дугаар	хүүгийн хэмжээ
2016.01.14	12.0 / 10.0	2016.01.18 №61	10.2
2016.05.05	10.5 / 8.5	2016.05.17 №15	9.0
2016.08.18	15.0 / 14.0	2016.12.15 №33	15.0
2016.12.19	14.0 / 13.0		

Тайлант онд НДҮЗ-ийн 2014 оны 29 дүгээр тогтоолд заасны дагуу хадгаламжийн хүүгийн түвшинг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан 3 удаа өөрчлөн тогтоосон ба НДҮЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 15-ны 33 дугаар тогтоолоор хадгаламжийн хүүг 15.0 хувь болгосон байна.

1.1.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийн 40.9 хувь, эцсийн үлдэгдлийн 32.2 хувийг төрийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн 2016 оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,325.4 тэрбум төгрөг байснаас 383.8 тэрбум төгрөгөөр буурч 941.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

1.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант оны эхэнд 366.7 тэрбум төгрөг байснаас 74.0 тэрбум төгрөг буюу 20.2 хувиар буурч 292.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ба 99.9 хувь харилцах дансанд, үлдэх 0.1 хувь кассанд байршиж байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг зөрчиж Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр Булган, Баян-Өлгий, Ховд аймгуудын ОНТЕЗ-дын харьяа зарим байгууллагууд арилжааны банкуудад 30 харилцах данс нээж, 0.6 тэрбум төгрөгийн орлогын, 0.5 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн, мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн, мөнгөн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, зөрүүтэй тайлагнасан, тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн, бүртгэл, тайлагнал, баталгаажуулалт, санхүүгийн сахилга бат, хариуцлага алдагдсан зэрэг нийт 2.8 тэрбум төгрөгийн нийтлэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал: Нийслэл 0.5 тэрбум, Ховд 1.2 тэрбум, Сүхбаатар 0.1 тэрбум, Хөвсгөл 0.5 тэрбум, Завхан 0.3 тэрбум, Орхон 0.2 тэрбум төгрөгийн алдаа зөрчлүүд тус тус гаргасан байна. Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг зөрчиж, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Хоёр. Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 124.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлд Боловсролын зээлийн сангаас Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан “Оюутны хөгжлийн зээлийн журам”-ын дагуу оюутны хөгжлийн зээлийг санхүүжүүлэхээр банкуудад олгосон эх үүсвэр 8.0 тэрбум, Төрийн банкны 101.7 тэрбум, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ТӨХК-ийн 15.0 тэрбум төгрөгөөр тайлагнасан байна.

2.1 Нийгмийн даатгалын сангийн богино хугацаат хөрөнгө оруулалт

Нийгмийн даатгалын сангийн богино хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 140.0 тэрбум төгрөг (Засгийн газрын бонд 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, хугацаа 2 жил, хүү 12.0) байсан бол тайлант онд 83.0 тэрбум төгрөгийн төлбөр хийгдэж, 57.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэлтэй байна.

2016 онд бондын хүүгийн орлого 13.3 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын холбогдох сангуудад төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. Бондын үлдэгдэл болон бүтэц

Сангийн төрөл	Эхний үлдэгдэл	Төлбөр хийгдсэн бонд	/сая.төг/	
			Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь
Тэтгэврийн сан	20,000.0	20,000.0	0.0	0.0
Эрүүл мэндийн даатгалын сан	49,232.0	16,032.0	33,200.0	58.2
ҮОМШӨ-ий сан	53,448.0	36,548.0	16,900.0	29.7
Ажилгүйдлийн сан	17,320.0	10,420.0	6,900.0	12.1
Нийт дүн	140,000.0	83,000.0	57,000.0	100.0

Гурав. Авлага, урьдчилгаа

3.1 Авлага

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 6,203.6 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 4,627.2 тэрбум төгрөгөөр тайлагнаж өмнөх онтой харьцуулахад 1,576.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт авлагын 15.4 хувийг төсөвт байгууллага, 10.8 хувийг төсөл, сан, 52.4 хувийг төрийн сан, 21.4 хувийг төрийн болон орон өмчит хуулийн этгээдийн авлага эзэлж байна.

3.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын авлага

ТЕЗ-дын авлагын эхний үлдэгдэл 2,734.2 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 1,862.7 тэрбум төгрөгөөр тайлагнасан нь өмнөх онтой харьцуулахад 871.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

ТЕЗ-дын нийт авлагын 71.7 хувь буюу 1,336.3 тэрбум төгрөгийг Сангийн яам, ХХААХҮЯ болон БСШУСЯ-ын харьяа байгууллагуудын авлага эзэлж байна. Тухайлбал:

- Хөгжлийн банкны авлага 384.1 тэрбум, “Мон Пи-9” төслийн нэгжийн авлага 139.1 тэрбум, Хадгаламж даатгалын корпорацийн авлага 106.8 тэрбум төгрөг;
- ЖДҮХС-гийн авлага 293.5 тэрбум, ТЭДС-гийн авлага 77.3 тэрбум, Бага оврын трактор худалдан авах төслийн нэгжийн авлага 52.1 тэрбум төгрөг;
- Боловсролын зээлийн сангийн авлага 131.6 тэрбум, МУБИС-ийн 10.2 тэрбум, ШУТИС-ийн 8.6 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн авлага зэрэг томоохон дүнтэй авлагууд байна.

Аудитын илрүүлэлт:

- Доорх яамдын харьяа зарим байгууллагууд авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Эдгээрээс томоохон дүнтэй дараах газруудыг дурдвал:
 - ХНХЯ 22.3 тэрбум;
 - БОАЖЯ 0.5 тэрбум;
 - БХБЯ 11.1 тэрбум;
 - ЗТХЯ 1.8 тэрбум;
 - ХХААХҮЯ 230.8 тэрбум төгрөг байна.
- Он дамжин хуримтлагдсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй, төлөгдөх найдваргүй болох эрсдэлтэй авлага байна. Үүнээс томоохон дүнтэй доорх газруудыг нэрлэвэл:
 - Сангийн яам 1.7 тэрбум;
 - ЗТХЯ 2.0 тэрбум;
 - ХХААХҮЯ 107.4 тэрбум төгрөг байна.

3.1.2 Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн тайлангаар нийт 3,438.8 тэрбум төгрөгийн авлага тайлагнаснаас Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд давхардсан ажил гүйлгээний 1,016.1 тэрбум төгрөгийн цэвэрлэх бичилтийг хийж, 2,422.7 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд ихээхэн хувь эзэлж байгаа дараах авлага байна. Үүнд:

- Сангийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар Хүний хөгжил санд хуримтлагдсан нийт 1,071.9 тэрбум төгрөгийн өрийг улсын төсөвт шилжүүлэн бүртгэж Ирээдүйн өв сангаас авах авлагаар тусгасан;
- 4000 болон 40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд “ТОСК” ТӨҮГ болон арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 126.1 тэрбум төгрөг, Төрийн банкаар дамжуулан хэрэгжүүлж буй 6 хувийн хүүтэй орон сууцны зээлийн эргэн төлөлтийн 60.9 тэрбум төгрөгийн авлага;
- Сайн малчин хөтөлбөрийн хүрээнд Төрийн банк болон Хаан банкаар дамжин хэрэгжсэн зээлийн эргэн төлөлтийн 79.7 тэрбум төгрөгийн авлага;

- УИХ-ын 2008 оны “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай” 42 дугаар тогтоолын дагуу бүрдүүлсэн нийт 101,941 тонн улаан буудайн нөөцийн үлдэгдэлтэй холбогдох 30.0 тэрбум төгрөгийн авлага;
- Анод болон Зоос банкны эрх хүлээн авагчаас авах 80.1 тэрбум, 6787 зээлдэгчидтэй холбоотой банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөрийн авлага 28.7 тэрбум, татан буугдсан 26 хадгаламж, зээлийн хоршоодын 20.6 тэрбум төгрөгийн авлага;
- ЖДҮХС-гийн зээлийн 140.1 тэрбум төгрөгийн авлага;
- Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эхний үлдэгдэл 1,567.7 тэрбум төгрөгөөр тайлагнагдсанаас тайлант онд зээлийн ашиглалт 38.7 тэрбум, Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-145/147 дугаар тушаалаар нэмж бүртгэсэн зээл 17.6 тэрбум, ханшийн зөрүү 225.3 тэрбум, нийт 281.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, эргэн төлөлтөөр 23.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлж, Засгийн газрын 2016 оны 123 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны 136 дугаар тушаалаар “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн 40.9 тэрбум төгрөгийн зээл, Сангийн сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар “МонСам” ХХК-ийн 7.3 тэрбум, нийт 71.9 тэрбум төгрөгөөр буурч 1,777.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүүгийн төлбөрт 9.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлжээ.

Дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэн төлөгдөх найдваргүй зээл өмнөх онд 228.4 тэрбум төгрөг байснаас ханшийн зөрүү 48.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 7.3 тэрбум төгрөгийн залруулга хийгдэж 269.2 тэрбум төгрөг болсон байна.

Дээрх зээл 10 төрлийн валютаар олгогдсон бөгөөд тайлант онд ханшийн зөрүүгээр 225.3 тэрбум төгрөг /ам.долларын зээл 97.6 тэрбум, зээлжих тусгай эрхийн зээл 53.0 тэрбум, Японы иен 28.0 тэрбум гэх мэт/-өөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны авлага, өр төлбөрийн үлдэгдэл нийт 2.7 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албанаас авах 20.6 тэрбум төгрөгийн авлага Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “... хохирогчдын төлбөрийг барагдуулсны дараа энэ хуулийн 4.1-д заасан төлбөрийг улсын төсөвт буцаан төлж дуусгана” гэж заасны дагуу 2014 оноос хойш өөрчлөлт ороогүй;
- Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийг нөхөж тооцоо нийлэх ажлыг хийж гүйцэтгэж байгаа хэдий ч он удаан жил бүртгэгдэж, эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон зэргээс шалтгаалж тооцоо нийлж баталгаажуулаагүй 419.9 тэрбум төгрөгийн авлага байна. Түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагчдын 377.6 тэрбум, орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын 21.7 тэрбум, төрийн өмчит үйлдвэрийн газрын 24.6 тэрбум төгрөгийн авлагыг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Монгол Улсын 2016 оны төсвийн тодотголоор “Сайн хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг санхүүжүүлэх зорилгоор нийт 596.0 тэрбум төгрөгийг Сангийн яамны төсөвт “дүрмийн сан” гэсэн ангиллаар батлагдсан төсвөөс “Сайн хувьцаа” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газарт хувьцаагаа худалдахаар хүсэлт гаргасан иргэдийн хувьцааг буцаан авахад 360.0 тэрбум төгрөгийг арилжааны банкаар дамжуулан олгосон байна. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь Засгийн газрын 2011 оны 98, 2012 оны 116, 201 дүгээр тогтоолуудын дагуу “Эрдэнэс Таван толгой” ТӨХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлэхтэй холбоотой бүртгэлийг гүйцэтгэж байна. Гэвч “Эрдэнэс Таван толгой” ТӨХК-ийн санхүүгийн тайлан бүртгэлд УИХ, Засгийн газраас гаргасан тогтоолын дагуу төр, иргэн, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэхтэй холбоотой хувьцааны бүртгэлийг бүртгээгүй, хувь нийлүүлсэн хөрөнгийг тайланд тусгаагүй байна.

3.1.3 Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн авлага 122.4 тэрбум төгрөг болж 102.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн тайланд төрөөс тэтгэврийг нь хариуцах

иргэдийн татаасны авлага 9.5 тэрбум, НДШ-ийн авлага 103.9 тэрбум, сайн дурын даатгалын авлага 0.02 тэрбум, зээлийн хүүгийн авлага 0.3 тэрбум, үйл ажиллагааны авлага 8.5 тэрбум, бусад 0.2 тэрбум төгрөгийн авлагыг тус тус тайлагнасан байна.

Тайлант онд улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлага 123.6 тэрбум төгрөгөөр буурсан бол НД-ын болон ЭМД-ын шимтгэлийн авлага 25.7 хувь буюу 21.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Төрөөс хариуцах иргэдийн даатгалын татаас, санхүүжилтийн авлага 128.4 тэрбум төгрөгийг тайлант онд бүрэн барагдуулсан нь авлага буурахад голлох нөлөө үзүүлсэн байна.

Нийт авлагын 16.3 тэрбум төгрөг нь 2014 онд болон түүнээс өмнө үүссэн он дамжин хуримтлагдсан авлага байна.

Хүснэгт 8. Нийгмийн даатгалын сангийн авлага сангийн төрлөөр

Сангийн нэр	2016 он	/сая.төг/ Эзлэх хувь
Тэтгэврийн даатгалын сан	80,584.4	65.8
Тэтгэмжийн даатгалын сан	6,662.9	5.4
Ажилгүйдлийн даатгалын сан	1,665.6	1.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	6,871.1	5.6
Эрүүл мэндийн даатгалын сан	17,802.3	14.5
Үйл ажиллагааны авлага	8,556.8	7.0
Хүүгийн авлага	295.9	0.3
Нийт дүн	122,439.0	100.0

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдэлд 2010 оноос өмнө үүссэн, дампуурсан арилжааны 6 банкттай холбоотой 5.5 тэрбум, НӨХГ-ын 0.6 тэрбум төгрөгийн он дамжсан авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй, НДШ-ийн авлага жил бүр өссөн байна.

3.1.4 Төрийн өмчит хуулийн этгээдийн авлага

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төрийн өмчит хуулийн этгээдийн авлага оны эхэнд 1,667.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 720.9 тэрбум төгрөгөөр буурч тайлант оны эцэст 946.5 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК, “Дулаан шарын гол” ТӨХК, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК, “Харгуй” ТӨХК, “Төв АЗЗА” ТӨХК, “МИАТ” ТӨХК, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ, Зээлийн батлан даалтын сан, МУИС, МУБИС, “Буянт ухаа спортын ордон” ТӨҮГ, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, ИНЕГ зэрэг байгууллагууд нийт 18.7 тэрбум төгрөгийг авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- “Увс АЗЗА” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК, ИНЕГ, “МИАТ” ТӨХК, МУИС, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор зэрэг байгууллагууд он дамжсан, хуримтлагдсан нийт 3.7 тэрбум төгрөгийн авлагатай байна.

3.1.5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлага

ОНТЕЗ-дын авлага оны эхэнд 223.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас тайлант оны эцэст 227.0 тэрбум төгрөг болж 3.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: Нийслэл 9.2 тэрбум, Дорноговь аймаг 1.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, зааврыг мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг хугацаанд нь барагдуулаагүй, бүртгэлийг аккрузл сууриар бүртгээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг нийт 21.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрлээ. Тухайлбал: Нийслэл 0.4 тэрбум, Дорнод 1.4 тэрбум, Ховд 1.9 тэрбум, Сүхбаатар 1.7 тэрбум, Өмнөговь 10.9 тэрбум, Завхан 1.8 тэрбум төгрөгийн зэрэг авлагатай холбоотой зөрчлүүд илэрсэн байна.

3.2 Урьдчилгаа

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 715.4 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 849.3 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 133.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт урьдчилгаа дансны 97.7 хувь буюу 829.9 тэрбум төгрөг нь урьдчилж гарсан зардал байна.

Төв төрийн сан “М Си Эс интернейшнл” ХХК-ийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөх нөхцөлтэй Мандалговь-Тавантолгой-Оюутолгой 2 хэлхээтэй 220 КВт-ын Цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 КВт-ын дэд станцын барилга угсралтын 160.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын санхүүжилтийн үлдэгдэл төлбөр 65.0 тэрбум төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байна.

Урьдчилгаа дансыг байгууллагын төрлөөр авч үзвэл, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урьдчилгаа 451.1 тэрбум, төсөл, сангийн урьдчилгаа 187.5 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Эрчим хүчний яам нь 217.7 тэрбум төгрөгийн өртөгтэй Мандалговь-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн Цахилгаан дамжуулах дэд станцыг 118.2 тэрбум төгрөгөөр бүртгэж, 99.5 тэрбум төгрөгийн зөрүүтэйгээр данс бүртгэлд тусгасан;

Дөрөв. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 6,034.5 тэрбум төгрөг тайлант оны эцэст 5,565.9 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 468.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт урт хугацаат хөрөнгө оруулалт дансны 74.6 хувь буюу 4,154.5 тэрбум төгрөг нь урт хугацаат зээл байна.

Тайлант онд Сангийн сайдын 2016 оны 66 дугаар тушаалын дагуу Монгол Улсын ОУВС-д эзэмшиж буй 51.1 сая зээлжих тусгай эрхийг 72.3 сая болгон нэмэгдүүлэх зорилгоор 5.3 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх 7.3 сая ам.долларыг бэлэн мөнгөөр, 15.9 сая зээлжих эрхтэй тэнцэх төгрөгийн хугацаагүй, хүүгүй өрийн бичгийг ОУВС-д гаргаж 65.2 тэрбум төгрөгөөр хувь оролцоогоо нэмснээр нийт 205.9 тэрбум төгрөг болсон байна.

Төрийн банкинд оруулсан 28.0 тэрбум төгрөгийн хувь оролцоо, Хадгаламж даатгалын корпорацид оруулсан 35.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтад тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүү, эдийн засгийн яам /хуучин нэрээр/ Дорноговь аймгийн ЗДТГ хооронд 2003 онд 1.8 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж, тус хөрөнгийг “Чандмань илч” ХХК-д дамжуулан зээлдүүлсэн ч эргэн төлөлт хийгдээгүй байна.

Тав. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө

5.1 Бараа материал

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл 1,305.7 тэрбум төгрөг байснаас 250.1 тэрбум төгрөгөөр буурч 1,055.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнээс 62.6 хувийг төсөвт байгууллага, 4.9 хувийг төсөл, сан, 32.5 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

5.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал

ТЕЗ-дын бараа материалын үлдэгдэл тайлант оны эхэнд 1,147.7 тэрбум төгрөг байснаас 279.8 тэрбум төгрөгөөр буурч, 867.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон нь нийт бараа материалын 82.2 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж худалдан авсан 1.0 тэрбум төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63/37 дугаар зөвлөмж, 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 4/77 дугаар албан бичгээр ГХЯ-д ирүүлсэн чиглэлийн дагуу "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулахаар батлагдсан төсвөөс 12.4 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний ханган нийлүүлэгч, гүйцэтгэгчтэй шууд худалдан авах гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т "... босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалттай нийцээгүй;

5.1.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн бараа материал

Төрийн өмчит хуулийн этгээдийн бараа материалын эхний үлдэгдэл 599.9 тэрбум төгрөг байснаас 304.3 тэрбум төгрөгөөр буурч 295.6 тэрбум төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- "Эрдэнэс Таван толгой" ТӨХК-ийн бараа материалын дансанд бүртгэлтэй 3.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 26 ширхэг дугуй үйлдвэрлэлд ашиглагдах боломжгүй;
- "Шивээ овоо" ТӨХК нь худалдан авсан 0.2 тэрбум төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байна.

5.1.3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа материал

ОНТЕЗ-дын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 157.9 тэрбум төгрөг байснаас тайланд онд 29.8 тэрбум төгрөгөөр өсөж, оны эцсийн үлдэгдэл 187.7 тэрбум төгрөгөөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ: Хэрэгцээнээс илүү хүнсний материал худалдан авч нөөцөлсөн, бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, ашиглалтын зардлыг зөрүүтэй бүртгэсэн, бараа материалын орлого аваагүй зэрэг 0.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- Нийслэл: Бараа материалын тайланд 0.3 тэрбум төгрөгийн материалыг тусгажгүй зардлаар шууд бүртгэсэн, 0.2 тэрбум төгрөгийн бараа материалын нэр, төрлийн тайланг гаргаагүй, хандив, тусламжаар ирсэн 0.2 тэрбум төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн заалтыг зөрчиж 0.8 тэрбум төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зэрэг 1.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- Орхон: ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчиж худалдан авалт хийсэн, бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлогоор тусгахгүй шууд зардлаар бүртгэсэн, нэр төрлийн хөдөлгөөний тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй

зарцуулсан, тооллогод бүрэн хамруулаагүй, тушаал шийдвэргүй данс бүртгэлээс хассан, зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг нийт 0.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.

5.2. Бусад эргэлтийн хөрөнгө

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 11.5 тэрбум төгрөг байсан бөгөөд 2,593.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эцсийн үлдэгдэл 2,605.1 тэрбум төгрөг болсон байна.

Бусад эргэлтийн хөрөнгө тайлант онд 2,593.6 тэрбум төгрөгөөр өссөн нь ТЕЗ-дын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ашиглалтад ороогүй барилга байгууламж, хуваарилагдаагүй тоног төхөөрөмжүүдийг эргэлтийн хөрөнгө дансанд шинээр бүртгэсэнтэй холбоотой байна.

Зургаа. Үндсэн хөрөнгө

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 12,226.5 тэрбум төгрөг байснаас 1,033.2 тэрбум төгрөгөөр өсөж, тайлант оны эцэст 13,259.7 тэрбум төгрөг болсон байна.

Нийт хөрөнгийн 97.1 хувийг биет хөрөнгө, 2.9 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

6.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 72.1 хувийг ТЕЗ-дын үндсэн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- БХЯ-ны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга, байгууламж дансны үлдэгдэл 47.5 тэрбум төгрөг байгаагаас 43.3 тэрбум төгрөгийн барилга байгууламж ашиглалтад орсон боловч ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудал шийдвэрлэгдээгүй;
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд олон жил хуримтлагдсан, бичиг баримтын бүрдэл дутуу, шилжүүлэхэд бэлэн болсон 13.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэх талаар тодорхой шийдвэрт хүрээгүй;
- ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон 386.7 тэрбум төгрөгийн зам, гүүрийн үндсэн хөрөнгө бүрэн ашиглалтад орсон боловч эдгээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн 11 төслийн санхүүгийн тайланд дуусаагүй барилга дансанд бүртгэсэн;
- Нийт 112.4 тэрбум төгрөгийн дуусаагүй барилгын дүнтэй “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх”, “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах” төслүүдийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй;
- Дархан-Уул аймагт байрлах 36.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах зориулалттай 15.9 тэрбум төгрөгийн ашиглалтын шаардлага хангахгүй элеваторыг худалдан авсан;
- Хөгжлийн банкнаас авсан 3,117.0 тэрбум төгрөгийн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр санхүүжүүлсэн хөрөнгийг зарим ТЕЗ-д данс бүртгэлдээ бүрэн тусгаагүй, тооцоо нийлж эцэслээгүй байна.

6.2 Нийгмийн даатгалын сангийн үндсэн хөрөнгө

Нийгмийн даатгалын сангийн санхүүжилтээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын зарим ажлууд үр дүн багатай, үргүй зардал гаргах нөхцөлийг бий болгосон байна. Тухайлбал: 2015 оны 12 дугаар сараас 2016 оны 3 дугаар сар хүртэл Өмнөговь аймгийн Ханбогд, Дархан-Уул аймгийн Шарын гол, Ховд аймгийн Булган, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Архангай аймгийн Хайрхан сумдад нийт 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй сум дундын нийгмийн даатгалын тасгийн барилга барьсан байна.

6.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийн 25.1 хувь, эцсийн үлдэгдлийн 27.9 хувийг төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө эзэлж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн нийт үндсэн хөрөнгө тайлант оны эхэнд 3,072.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 1,943.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 964.8 тэрбум төгрөгөөр хасагдаж, элэгдлийн болон дахин үнэлгээний зардлын 352.4 тэрбум төгрөгөөр хорогдож, 3,698.1 тэрбум төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК Засгийн газрын 2016 оны 123 дугаар тогтоолоор хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 45.6 сая ам.доллар буюу 113.5 тэрбум төгрөгийн мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн хөрөнгийг бүртгэлд авах тухай ТУЗ-ийн 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 57/04 дүгээр тогтоол гарсан боловч хэрэгжүүлээгүй;
- Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалт”-ын 14-т заасан “Монгол Улс дахь БНЧУ-ХБНЮУ-ын ЭСЯ, АНУ-ын Энх Тайваны Корпусын эзэмшлийн Дипломат-95 айлын орон сууц” гэсэн заалтыг Засгийн газрын 2016 оны 223 дугаар тогтоолоор хүчингүй болгож, 2016 оны 315 дугаар тогтоолоор ГХЯ-ны албан хаагчдад үнэ төлбөргүй хувьчлахаар шийдвэрлэсэн;
- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт “АСЕМ”-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн гаалийн мэдүүлгээрх 3.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 578 иж бүрдэл зочид буудлын тавилга, тоног төхөөрөмж хүлээн авсан бөгөөд ТӨБЗГ-аас албан ёсны шийдвэр гараагүй байхад Үндэсний зөвлөлийн 21 дүгээр хуралдааны шийдвэрийн дагуу зочид буудлын тавилгуудыг АСЕМ-ын түнш зочид буудлууд болон хувь хүн, ААН-д 1.2 тэрбум төгрөгөөр үнэлж худалдсан, борлуулсаны 0.8 тэрбум төгрөгийн орлогыг хүлээн аваагүй, хүлээн авсан 0.4 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй, 61 иж бүрдэл буюу 0.1 тэрбум төгрөгийн тавилгыг төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн;
- “ТОСК” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2016 оны А/49, А/70 дугаартай тушаалын дагуу 32 айлын 1,480.3 м2 талбайтай 2.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Нийслэлийн орон сууцны фондод үнэ төлбөргүй шилжүүлж үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн;
- Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолоор Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборын санхүүжилтэд 14.2 тэрбум төгрөгийг АНУ-ын Экспорт Импортын банкнаас зээл авах хүртэлх хугацаанд Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвшөөрсний дагуу “ТОСК” ТӨҮГ-ын дансаар тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй ажил гүйлгээг дамжуулан санхүүжилт хийж, 18.0 тэрбум төгрөгийг авлагаар бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр
 - “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ Lexus-570 маркийн автомашиныг 0.2 тэрбум, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ Nissan Patrol маркийн автомашиныг 0.2 тэрбум төгрөгөөр худалдан авсан.
 - “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК 1.3 тэрбум төгрөгийг ажилчдын орон сууц баруулахад зарцуулсан;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хөрөнгө оруулалтаар хийгдсэн 31.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгээгүй байна.

6.4 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын үндсэн хөрөнгө

ОНТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант оны эхэнд 3,412.3 тэрбум төгрөг байснаас 561.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 271.4 тэрбум төгрөгөөр хасагдаж, оны эцсийн үлдэгдэл 3,702.8 тэрбум төгрөгөөр тайлагнагдсан байна.

Тайлант онд барилга, байгууламж 122.4 тэрбум, тээврийн хэрэгсэл 25.7 тэрбум, зам гүүр 53.0 тэрбум, машин, тоног төхөөрөмж 66.6 тэрбум, бусад үндсэн хөрөнгө 288.9 тэрбум, биет бус хөрөнгө 5.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь улсын төсвийн болон орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр бий болсонтой холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд тайлант онд олж бэлтгэсэн 0.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн дансанд 0.9 тэрбум төгрөгийн бараа материалыг бүртгэсэн, үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь буруу ангилан бүртгэсэн, тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 0.9 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 0.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, дуусаагүй барилга данснаас 0.3 тэрбум төгрөгийн хасалт хийж, барилгын өртгийг капиталжуулахдаа засгийн газрын санг бууруулж, буруу бичилт хийсэн;
- Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд 0.6 тэрбум төгрөгийн хандив тусламжаар авсан үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, 1.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Өмнөговь аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд 8.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Говь-Алтай аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комисс томилоогүй, тооллого хийгээгүй, хангалтгүй хийсэн, тооллогын бүртгэлийн дүн нягтлан бодох бүртгэлийн үлдэгдлээс зөрүүтэй зэрэг нийт 7.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн;
- Завхан аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд 0.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг хууль бус шийдвэрээр бүртгэлээс хассан байна.

Долоо. Өр төлбөр

Нийт өр төлбөр оны эхэнд 19,685.1 тэрбум төгрөг байснаас 5,158.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 24,843.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 9. Нийт өр, төлбөрийн дансны ангилал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая.төг/ Дүнд эзлэх хувь
Нийт өр төлбөрийн дүн	19,685,123.8	24,843,660.9	5,158,537.1	100
Богино хугацаат өр төлбөр дүн	5,794,299.0	3,854,807.9	-1,939,491.1	15.5
Урт хугацаат өр төлбөр дүн	13,890,824.8	20,988,853.0	7,098,028.2	84.5
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	318,676.7	252,298.2	-66,378.5	1.0
Төсөл сан	1,080,885.8	103,505.0	-977,380.8	0.4
Төрийн сан	11,185,888.1	16,907,962.1	5,722,074.0	68.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	7,099,673.2	7,579,895.6	480,222.4	30.5

Төрийн сангийн нийт өр төлбөр 16,907.9 тэрбум төгрөг хүрсний 99.9 хувийг Төв төрийн сангийн өр төлбөр, үлдэх хувийг орон нутгийн төрийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр 7,579.9 тэрбум төгрөг болж, үүний 97.0 хувийг төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр, 3.0 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр эзэлж байна.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт өр төлбөрөөс үнэт цаас (бонд, вексель) болон зээлийн өглөг 91.8 хувь буюу 22,814.6 тэрбум төгрөгийг эзэлж байна.

Хүснэгт 10. Үнэт цаас (бонд, вексель), зээлийн өглөг

/сая.төг/

Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Нийт дүн	15,003,998.9	22,814,594.4	7,810,595.5	100.0
Төв төрийн сангийн өр төлбөр дүн	10,999,369.1	16,718,464.8	5,719,095.7	73.3
Дотоод бонд, векселийн дүн	2,949,604.9	4,164,232.8	1,214,627.9	18.3
Гадаад үнэт цаас, бондын дүн	3,456,460.7	5,570,905.4	2,114,444.7	24.4
Гадаад бонд дүн	3,315,798.4	5,380,467.6	2,064,669.2	23.6
ОУВС /үнэт цаас/	140,662.3	190,437.8	49,775.5	0.8
Гадаад зээл	4,593,303.5	6,983,326.6	2,390,023.1	30.6
Төрийн болон ОНӨ хуулийн этгээдийн өр төлбөрийн дүн	4,004,629.8	6,096,129.6	2,091,499.8	26.7
Үнэт цаас өглөг	0.0	22,709.8	22,709.8	0.1
Зээлийн өглөг	3,865,898.4	6,025,317.5	2,159,419.1	26.4
Бусад байгууллагын зээлийн өглөг	138,731.4	48,102.3	-90,629.1	0.2

Тайлант оны эцэст Төв төрийн сангийн дотоод бонд, векселийн өглөг 4,164.2 тэрбум, гадаад бонд 5,380.5 тэрбум, ОУВС-гийн хувь оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гаргасан үнэт цаас 190.4 тэрбум, гадаад зээл 6,983.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв төрийн сангийн бонд, вексель болон зээлийн өглөг нийт 5,719.1 тэрбум төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 11. Төв төрийн сангийн бонд, гадаад зээлийн өр төлбөр

/сая.төг/

Үзүүлэлт	Дотоод бонд, вексель	Гадаад бонд	Гадаад зээл	Нийт
Нэмэгдсэн дүн	4,445,987.2	2,064,799.2	2,745,009.0	9,255,795.4
Тухайн онд шинээр гаргасан бонд, вексель авсан зээл	4,381,013.9	1,021,245.0	1,350,058.0	6,752,316.9
Ханшийн алдагдал	64,973.3	1,043,554.2	1,223,972.2	2,332,499.7
Залруулгаар нэмэгдсэн			170,978.8	170,978.8
Хасагдсан дүн	2,138,220.5	-	217,872.8	2,356,093.3
Үндсэн төлбөр	2,138,220.5		135,614.7	2,273,835.2
Зээл чөлөөлсөн			37,439.0	37,439.0
Залруулгаар хасагдсан болон ханш			44,819.1	44,819.1
Хүү хөнгөлөлтийн төлбөр дүн	450,022.8	239,176.1	74,395.7	763,594.6
Хүүгийн төлбөр	363,608.3	239,176.1	74,395.7	677,180.1
Хөнгөлөлт	86,414.5			86,414.5

Төв төрийн сангийн бонд, вексель, урт хугацаат зээл дараах байдлаар нэмэгджээ. Үүнд:

- Дотоод бонд, векселийн өглөг нийт 4,446.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс төсвийн дутагдлыг санхүүжүүлэхэд 2,066.7 тэрбум, сайн хөтөлбөрийг санхүүжүүлэхэд 596.0 тэрбум, Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 1,000.0 тэрбум, Хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэхэд 239.8 тэрбум, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх вексель 478.5 тэрбум, Хүний хөгжил сангийн бондын ханшийн алдагдал 65.0 тэрбум төгрөг байна.

- Гадаад бонд Засгийн газрын 2016 оны 17 дугаар тогтоолоор санхүүгийн хэрэгцээг бүрдүүлэх зорилгоор 1.0 тэрбум хүртэлх ам.долларын бондыг Олон улсын зах зээлд гаргахаар зөвшөөрч 500.0 сая ам.доллартай тэнцэх 1,021.2 тэрбум төгрөгийн 10.785 хувийн хүүтэй Мазаалай бонд гаргасан байна. Ханшийн зөрүүний алдагдал Чингис бонд 740.3 тэрбум, Дим сам бонд 79.6 тэрбум, Мазаалай бонд 223.7 тэрбум, нийт 1,043.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

- Тайлант онд гадаад зээл ашиглалт 1,350.0 тэрбум, ханшийн алдагдлаас 1,224.0 тэрбум, санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлсэн актын зөрүү болон Монголбанк дахь зээлийг шилжүүлэн бүртгэснээс 171.0 тэрбум, нийт 2,745.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төв төрийн сангийн бонд, вексель, урт хугацаат зээл дараах байдлаар хасагдсан байна. Үүнд:

- Төсвийн дутагдлыг санхүүжүүлэх бондын үндсэн төлбөрт 1,472.2 тэрбум, Сайн хөтөлбөрүүдийг зогсоох Засгийн газрын 2016 оны 33 дугаар тогтоолын дагуу Сайн хөтөлбөрт зориулан гаргасан бондыг буцаан худалдан авахад 142.3 тэрбум, Хүний хөгжил сангийн бондын төлбөрт 177.4 тэрбум, хөрөнгө оруулалтын векселийн төлбөрт 331.1 тэрбум, тусгай зориулалтын бондын төлбөрт 15.2 тэрбум, нийт 2,138.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлсөн байна.

- Олон улсын байгууллагаас авсан урт хугацаат гадаад зээлийн үндсэн төлбөрт 135.6 тэрбум, БНХАУ-тай хийсэн өр чөлөөлөх хэлэлцээрийн дагуу 37.4 тэрбум төгрөгийн өрийг чөлөөлж, 44.8 тэрбум төгрөгөөр залруулагдаж нийт 217.8 тэрбум төгрөгөөр гадаад зээлийн өр хасагдсан байна.

Мөн бонд, вексель, гадаад зээлийн хүү, хөнгөлөлтийн төлбөрт нийт 763.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлсөн байна.

7.1 Богино хугацаат зээлийн өглөг

Богино хугацаат зээлийн өглөг өмнөх оноос 554.8 тэрбум төгрөгөөр буурч 548.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зээлийн өглөг өмнөх оноос 443.2 тэрбум төгрөгөөр буурч 541.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарч нийт богино хугацаат зээлийн өглөгийн 98.7 хувийг эзэлж байна. Тухайлбал: Төрийн банк 339.2 тэрбум, Хөгжлийн банк 127.9 тэрбум, “МИАТ” ТӨХК 64.2 тэрбум төгрөгийн томоохон дүнтэй өглөгүүд тус тус эзэлж байна.

7.2 Дансны өглөг

Дансны өглөг 2,121.2 тэрбум төгрөгөөр буурч 1,133.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 67.5 хувь, төрийн сан 12.4 хувь, төсөвт байгууллага 17.4 хувь, төсөл сан 2.7 хувийг тус тус эзэлж байна.

Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлөх нийт өглөг 45.8 тэрбум төгрөг байгаагийн Хөгжлийн банк 10.6 тэрбум, “МИАТ” ТӨХК 7.8 тэрбум, ИНЕГ 4.2 тэрбум, “Монголын төмөр зам” ТӨХК 2.0 тэрбум, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 1.6 тэрбум, “Эрдэнэс Таван толгой” ТӨХК 1.5 тэрбум, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХК 1.0 тэрбум төгрөг, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 6.4 тэрбум төгрөгийн ихээхэн дүнтэй өр тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг өмнөх оноос 27.4 тэрбум төгрөгөөр өсөж 45.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба дээрх өр төлбөрийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа төрийн өмчит хуулийн этгээдүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 399.3 тэрбум төгрөг байгаа боловч албан татвар, шимтгэлийг төлөх хуулийн хугацааг хэрэгжүүлэн ажиллаагүй;
- Мөн 1.1 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, 0.7 тэрбум төгрөгийг дутуу тайлагнасан, өмнөх оны 3.8 тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг барагдуулаагүй;
- Хүний хөгжил сангийн бондын хүүгийн төлбөр 17.0 тэрбум төгрөгийг дансны өглөгөөр бүртгэсэн;
- Төсөвт 2014 онд татан төвлөрүүлсэн 1.9 тэрбум, 2015 онд татан төвлөрүүлсэн 2.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;

- Урт хугацаат зээлээс тайлангийн жилд төлөгдөх дүнг богино хугацаат зээлийн ангилалд шилжүүлэн бүртгээгүй;
- Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-д заасны дагуу тодруулга бүрт тайлбар, тэмдэглэлийг бүрэн хийгээгүй байна.

7.3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр

ОНТЕЗ-дын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 489.4 тэрбум төгрөгөөс 139.5 тэрбум төгрөгөөр буурч 349.9 тэрбум төгрөгөөр тайлагнагдсан байна.

Хүснэгт 12. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая.төг/ Дүнд эзлэх хувь
Нийт өр төлбөр	489,413.7	349,896.9	-139,516.8	100.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	254,066.9	215,995.3	-38,071.6	61.7
Богино хугацаат зээлийн өглөг	14,497.9	7,832.3	-6,665.6	2.2
Богино хугацаат өглөг	120,848.1	140,870.6	20,022.5	40.3
Урьдчилж орсон орлого	118,720.9	67,292.4	-51,428.5	19.2
Урт хугацаат зээл	235,346.8	133,901.6	-101,445.2	38.3

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын дамжуулан зээлийн өглөгийн талаар:

Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээс орон нутагт дамжуулан зээлдүүлсэн зээлийн өглөг Азийн хөгжлийн банкны 33, Дэлхийн банкны 10, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 2, Франц улсын 1, БНСУ-ын 2, Испани улсын 1, нийт 49 санхүүжүүлэгч байгууллагын 287.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байна.

Дээрх дамжуулан зээлийг аймаг, орон нутгийн гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, төвлөрсөн системд холбох, худаг гаргах зэрэгт зориулан олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 1994-2014 онд байгуулсан 42 зээлийн гэрээний 75.7 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хугацаандаа хуваарийн дагуу төлөгдөөгүй;
- Нийслэлийн 9 зээлдэгчийн 43.6 тэрбум, Баян-Өлгий 1 зээлдэгчийн 2.1 тэрбум, Булган 1 зээлдэгчийн 2.5 тэрбум, Орхон 1 зээлдэгчийн 23.0 тэрбум, нийт 71.2 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Найм. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар засгийн газрын хувь оролцооны нийт хэмжээ тайлант оны эхэнд 10,154.7 тэрбум төгрөг байснаас 3,838.4 тэрбум төгрөгөөр буурч 6,316.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 13 .Засгийн газрын хувь оролцооны бүтэц

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төг/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,697,680.9	4,155,062.1	-2,542,618.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	980,903.1	2,860,724.5	1,879,821.4
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	40.9	175.1	134.2
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	264.2	38,355.9	38,091.7
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	19,108.4	33,784.2	14,675.8
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	681,569.4	2,352,268.3	1,670,698.9
Хуримтлагдсан үр дүн	-190,021.9	-5,032,738.6	-4,842,716.7
Өмнөх үеийн үр дүн	-641,198.1	-1,538,042.4	-896,844.3
Тайлант үеийн үр дүн	451,176.2	-3,494,696.2	-3,945,872.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,954,324.3	1,892,819.3	-61,505.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	10,873.2	15,853.1	4,979.9
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-21.3		21.3
Засгийн газрын хувь оролцоо	10,154,721.2	6,316,303.9	-3,838,417.3

8.1 Төрийн өмчийн хувь оролцоо

ТЕЗ-ийн Засгийн газрын хувь оролцоо тайлант оны эхэнд 6,475.0 тэрбум төгрөг байснаас 65.7 хувь буюу 4,252.1 тэрбум төгрөгөөр хасагдаж, 2,222.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нийт засгийн газрын хувь оролцоо буурсан нь дараах өр, авлагыг санхүүгийн тайланд нэмж бүртгэн, өмнөх үеийн үр дүнд тусгаснаас шалтгаалсан байна. Тухайлбал:

- Улсын Их Хурлын 2016 оны 81 дүгээр тогтоол “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай”, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” тогтоолын дагуу Засгийн газар Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тооцоо нийлж, дүнг Засгийн газрын санхүүгийн тайланд тусгах шийдвэрийн дагуу 2016 оноос өмнөх зээлийн өр 2,773.2 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд тусгасан;
- Засгийн газрын 2016 оны 123 дугаар тогтоолоор БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэтгэл” төслийн хүрээнд “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн 48.8 тэрбум төгрөгийн зээлийг хөрөнгө оруулалтад тооцсон;
- Төв төрийн сангийн 2015 оны санхүүгийн тайланд тусгагдсан гадаад зээлийн үлдэгдлийг зээлдүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулснаар зээлийн өр 117.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 8.5 тэрбум төгрөгөөр хорогдуулсан;
- Төсөл, хөтөлбөр нэгжүүдийн 2016 оноос өмнө бүртгэгдээгүй байсан 762.6 тэрбум төгрөгийн зээлийг нэмж бүртгэсэн;
- Хүний хөгжил сангийн тухай хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан 1,071.9 тэрбум төгрөгийн өрийг улсын төсөвт шилжүүлэх шийдвэрийн дагуу Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэсэн;
- Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт заасан Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэлд бүртгэгдсэн 1991, 1992, 1994 дугаартай юаний үлдэгдэлтэй зээлийг чөлөөлсний дагуу 37.4 тэрбум төгрөгийн зээлийг хүчингүй болгосон байна.

Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 125 төрийн өмчит хуулийн этгээдээс 123 нь тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанаас нийт 3,845.5 тэрбум төгрөгийн орлого олж, үйл ажиллагааны зардалд 3,741.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Эдгээрээс 63 байгууллага буюу 51.2 хувь нь 137.5 тэрбум төгрөгийн ашигтай, 48.8 хувь буюу 60 байгууллага нь 467.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол Аялал жуулчлалын үндэсний төв, Техник спортын төв үйл ажиллагаа явуулаагүй байна.

ТӨБЗГ-ын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор 2015 онд 26.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан 39 төрийн өмчит хуулийн этгээдээс 2016 оны улсын төсөвт төвлөрүүлэх 7.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн хэмжээг баталсан байна. Үүнээс 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрч, 3.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэх төлөвлөгөөгөө тасалжээ.

8.2 Орон нутгийн өмчийн хувь оролцоо

ОНТЕЗ-дын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Засгийн газрын хувь оролцооны эхний үлдэгдэл 3,679.7 тэрбум төгрөг байснаас тайлант онд 413.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 4,093.4 тэрбум төгрөгөөр тайлагнагдсан байна.

ОНТЕЗ-дын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 402 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 154 байгууллага 3.5 тэрбум төгрөгийн ашигтай, 234 байгууллага 103.1 тэрбум төгрөгийн алдагдалтай, 14 байгууллага нь ашиг, алдагдалгүй ажилласан байна. Тухайлбал: Нийслэлийн харьяа Ус сувгийн удирдах газар, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл, Зорчигч тээврийн нэгтгэл, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци, “Чандмань Налайх” ОНӨААТҮГ, СХД-ийн “Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ” ОНӨҮГ, “Багануур ус” ОНӨААТҮГ, Увс аймгийн Дулааны станцын ашиглалтын өмнөх захиргаа, Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ энерго” ОНӨҮҮГ, Сүхбаатар аймгийн “Дөрвөлж” ХХК, Хөвсгөл аймгийн “Хөвсгөл дулаан” ХХК, “Ус чандмань” ХХК, “Ус суваг нийтийн аж ахуй” ХХК, Дархан-Уул аймгийн “Дархан ус суваг” ХК, Баян-Өлгий аймгийн “Хала-Өркени” ОНӨААТҮГ, Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ОНӨҮҮГ гэх мэт.

Ес. Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн

9.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 4,615.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 1,482.2 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, 4.0 тэрбум төгрөгийн зөрчилд 154 акт тогтоож, 1,389.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 258 албан шаардлага хүргүүлж, 6.3 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 17 санал хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 1,733.5 тэрбум төгрөгийн 1850 зөвлөмж өглөө.

Тайлант хугацаанд 30 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, 20 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, 10 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд: БХБС, ГХС, ЗТХС, ЦАУЗБУК, НДС, УУХҮС, ХНХС, ХХААХҮС, ЭМС, ЭХС-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгөгдсөн.

9.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн 22 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 207.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 88.4 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, 3.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 675 акт тогтоож, 29.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 774 албан шаардлага хүргүүлж, 3.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 210 санал хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 83.1 тэрбум төгрөгийн 3140 зөвлөмж тус тус өгсөн байна.

Орон нутгийн ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 21 ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, харин Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгчээ.

9.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 772.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 110.5 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, 2.3 тэрбум төгрөгийн 9 төлбөрийн акт тогтоож, 56.6 тэрбум төгрөгийн 23 албан шаардлага өгч, 7.0 тэрбум төгрөгийн алдаа гаргасан 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлж, 596.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 455 зөвлөмж өгсөн.

Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь 25.5 тэрбум төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ болон холбогдох журмыг зөрчсөн байна.

Нийт 125 төрийн өмчит хуулийн этгээдээс 114 нь аудитад хамрагдаж, 84 нь “Зөрчилгүй”, 28 нь “Хязгаарлалттай”, 2 нь “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан байна.

Хүснэгт 14. Хязгаарлалттай” болон “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан байгууллагууд

Д/д	Байгууллагын нэр	Д/д	Байгууллагын нэр
“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”		13	“Дулаан Шарын гол” ТӨХК
1	“Монголын төмөр зам” ТӨХК	14	“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК
2	“Мон-Атом” ХХК	15	“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
“Хязгаарлалттай”		16	“Шивээ овоо” ТӨХК
1	“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК	17	“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК
2	“Багануур” ТӨХК	18	“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
3	“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК	19	“Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ
4	“Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ	20	Зээлийн батлан даалтын сан
5	“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК	21	Иргэний нисэхийн ерөнхий газар
6	“Хилийн цэргийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ	22	Шинжлэх ухаан технологийн их сургууль
7	“Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ	23	“Эрдэнэсант АЗЗА” ТӨХК
8	“Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ	24	“Эрдэнэс таван толгой” ТӨХК
9	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК	25	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК
10	“Монгол тамга” ТӨҮГ	26	“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ
11	“Монгол ус” ТӨҮГ	27	“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ
12	Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор	28	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Эдгээр байгууллагууд нь хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, биетээр оршин байхгүй, тооллого тооцоог хугацаанд нь хийгээгүй, он дамжсан, хугацаа хэтэрсэн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, орлогыг дутуу тусгасан, тэвчиж болох зардлыг зарцуулсан, төсөвт төлөх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төвлөрүүлсэн зэрэг нийтлэг зөрчил гаргасан байна.

9.4 Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

2016 онд зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 32 төсөл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 42 төсөл тус тус хэрэгжиж байна.

Хүснэгт 15. Төслийн санхүүжилтийн эх үүсвэр

Төслийн санхүүжилтийн хэлбэр	Төс лийн тоо	Нийт гэрээний дүн /сая нэгж/							
		төгрөг	доллар	евро	иен	Зээлжих тусгай эрх	Швей- царь франк	крон	юань
Зээлийн хөрөнгөөр	32	9,356.8	694.9	65.1	14,090.0	7.3			
Буцалтгүй тусламжаар	42	31,600.0	398.3	21.7	11,700.0		6.6	29.7	300.0
ДҮН	74	40,956.8	1,093.2	86.8	25,790.0	7.3	6.6	29.7	300.0
Монголбанкны тухайн өдрийн ханш			2,489.5	2,605.8	21.19		2,423.4	96.4	357.9

Төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй, үйл ажиллагаа явуулж буй нийт 28 төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөснөөс Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг зэргээс санхүүжүүлсэн 15 төслийн санхүүгийн тайланд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан гэрээ, хэлцэлд заасны дагуу хараат бус аудитын байгууллагыг сонгон аудит хийлгэсэн байна.

Харин Үндэсний аудитын газар 6, хараат бус аудитын компани 7, нийт 13 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудитыг хийж “Хязгаарлалттай” 1, “Зөрчилгүй” 12 санал дүгнэлтийг өгсөн байна.

Аудитаар нийт 31.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 14.8 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, 17.1 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг өгсөн байна.

9.5 Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудит

Аудитаар нийт 539.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрч, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 40 зөвлөмж өгөгдсөн байна.

Засгийн газрын 13 тусгай сангийн 2016 оны санхүүгийн тайлан аудитад хамрагдсанаас 6 санд “Зөрчилгүй”, 7 санд “Хязгаарлалттай” санал, дүгнэлт өгсөн байна.

Арав. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга

- Аудитаар Засгийн газрын 2016 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд 746.8 тэрбум төгрөгийн цэвэрлэх бичилт дутуу хийж мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг илүү илэрхийлсэн зөрчлийг залруулсан болно.

Арван нэг. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Засгийн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар 4 зөвлөмжийг Ерөнхий сайдад, 3 зөвлөмжийг Сангийн сайдад тус тус өгчээ. Үүнээс:

- Ерөнхий сайдад өгсөн 4 зөвлөмжийн биелэлтийг үнэлэхэд ТЕЗ-дын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилган, аудитын зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдээс 1 зөвлөмж нь хэрэгжих шатандаа, 3 нь хэрэгжээгүй;
- Сангийн сайдад өгсөн 3 зөвлөмжийн биелэлтийг үнэлэхэд орон нутгийн ТЕЗ-дад гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг харилцагч тус бүрээр бүртгэж, зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулж барагдуулах талаар өгсөн 1 зөвлөмж нь хэрэгжих шатандаа, 2 нь хэрэгжсэн байна.

Засгийн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн нийт 7 зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хянаж, үнэлэхэд 56.2 хувийн биелэлттэй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад хийсэн горим, сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн нь Аудитын Олон улсын стандарт 705, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2.20.2-т заасны дагуу Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах үндэслэлээр “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд:

1. Засгийн газрын 2016 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Барилга, хот байгуулалтын сайд, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд тус тус “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн;
2. “Эрдэнэс Таван толгой” ТӨХК-ийн санхүүгийн тайланд Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу төр, иргэн, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэхтэй холбоотой хувьцааг бүртгээгүй, хувь нийлүүлсэн хөрөнгийг тайланд тусгаагүй;
3. Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн 419.9 тэрбум, төсвийн ерөнхийлөн захирагчдын 377.6 тэрбум, орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын 21.7 тэрбум, төрийн өмчит хуулийн этгээдийн 22.5 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
4. Гадаад зээлийн хөрөнгөөс орон нутагт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 71.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн 75.7 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй;
5. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны авлага, өр төлбөрийн үлдэгдэл нийт 2.7 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан;
6. Хөгжлийн банкнаас улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй авсан зээлээр санхүүжүүлсэн 176 төсөл арга хэмжээний 594.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд бүрэн тайлагнаагүй;
7. Эрчим хүчний яам нь 217.7 тэрбум төгрөгийн өртөгтэй Мандалговь-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн Цахилгаан дамжуулах дэд станцыг 118.2 тэрбум төгрөгөөр бүртгэж 99.5 тэрбум төгрөгийн зөрүүтэйгээр данс бүртгэлд тусгасан;
8. Гадаад харилцааны яам "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн хөрөнгөөс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагуудад 1.2 тэрбум төгрөгөөр худалдсан, 1.9 тэрбум төгрөгийн /гаалийн үнэлгээгээр/ орчуулгын тоног төхөөрөмжийг түрээслүүлсэн, 12.4 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын журмыг зөрчиж шууд худалдан авалт хийсэн;
9. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.” гэж заасны дагуу зарим төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгүй байна.

10. Төрийн өмчит 60 хуулийн этгээд 2016 оны дэвшүүлсэн зорилтот түвшинг биелүүлээгүй, санхүүгийн тайлангаар гарсан алдагдал нь 2015 оноос 354.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
11. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй сум дундын нийгмийн даатгалын тасгуудын барилгын ашиглалтын зардлыг тооцоололгүйгээр барьсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

Монголбанкны санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэх хууль, эрх зүйн орчинг бий болгох.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД -Д:

1. “Эрдэнэс Таван толгой” ТӨХК-ийн хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг баталгаажуулах, хувьцааг бүртгэн хувь нийлүүлсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах;
2. Хөгжлийн банкаар дамжуулан улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн хөрөнгийг улсын болон орон нутгийн Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд бүрэн тусгах арга хэмжээ авах;
3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилган, аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;
4. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан Төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын албадын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр өгөөжийг дээшлүүлэх;
5. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдыг тодорхой болгох.

САНГИЙН САЙД-Д:

1. “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд бүрэн нэгтгэж хамруулах” гэсэн Олон улсын валютын сангаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
2. Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллах;
3. Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагад бүртгэлтэй 98.9 тэрбум төгрөг, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны тайланд бүртгэлтэй 21 зээлдэгчдийн 0.8 тэрбум төгрөг, нийт 99.7 тэрбум төгрөгийн шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон авлагыг санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаж байгаа асуудлыг эрх бүхий байгууллагад танилцуулж шийдвэрлэх;
4. Санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрүүтэй тайлагнагдсан Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны болон Тариалан эрхлэлтийг дэмжих

сантай холбоотой авлагын тооцоог дахин хянаж, үлдэгдлийг зөв дүнгээр баталгаажуулах;

5. Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;
6. Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т *“Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ”* гэсэн заалтыг зөрчиж зөвшөөрөлгүй нээсэн нийт 32 (улсын 2, орон нутгийн 30) арилжааны банкин дахь харилцах дансдыг хаах арга хэмжээ авах.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГАД:

1. Алдагдалтай ажиллаж байгаа, санхүүгийн зохистой харьцаа алдагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах талаар оновчтой арга хэмжээ авч, төсвийн ачааллыг багасгах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг тодорхой болгож, санхүүгийн нэгтгэсэн тайланд хамруулах.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА БОЛОН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Алдагдалтай ажиллаж байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зорилтот түвшин, гэрээний биелэлтийг хангуулж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах;
2. Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилган, аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллах, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээ авах.



2017 оны 06 сарын 06

А/109

Сүхбаатар-10

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, 16 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан"-г нэгдүгээр хавсралтаар, "Төсвийн захирагчид, төрийн өмчит хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Төсвийн захирагчид, төрийн өмчит хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн даманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт илрүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчид, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиглахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-г үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

MSAA-2017-06-06-001

070460

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of multiple rows of horizontal dashed lines spaced evenly down the page, providing a guide for letter height and placement. The background is plain white, and there are no margins or additional markings.

[illegible]

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.